ГОВЬСҮМБЭР АЙМАГ

# ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр Дугаар А/72 Шивээговь сум

Хяналтын цэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 4,2 дахь заалт, Сумын засаг даргын А/71 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар багийн малчин Мөнхбаатарын Билэгдэмбэрэлийн малд бог малын гоц халдвар мялзан өвчин гарсан нь Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 23-3691 дугаартай шинжилгээгээр баталгаажсан тул хорио цээрийн дэглэм тогтоосон байршилд тасралтгүй ажиллагаатай хяналтын цэйиг байгуулсугай.

2. Хяналтын цэгт ажиллах албан хаагчдыг 1 дүгээр хавралтаар баталсугай.

3. Хяналтын цэгт ажиллах албан хаагчдыг мэргэжлийн байгууллага болох аймгийн Онцгой байдлын газар, аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран томилгоожуулж, хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Ч.Сугармаа)-д даалагсугай.

4. Хязгаарлалтын бүсээс мал амьтан, хүн тээврийн хэрэгслийг гаргахгүй байх, сэжигтэй бүсээр дамжин өнгөрөх, хүн тэврийн хэрэгслийг халдваргүйжүүлэлтэд хамруулсаны дараа нэвтрүүлж, эргүүл хяналтыг хариуцлагатай хийж гүйцэтгэн, мэдээ мэдээллээ өдөр бүр сумын шуурхай штаб-д тайлагнахыг, хяналтын цэгт ажиллаж буй албан хаагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ

47123 234

Сумын Засаг даргын 2023 оны 05.р
сарын .19..-ны өдрийн .А/92 дугаар
захирамжийн хавсралт - 1

## ХЯНАЛТЫН ПОСТ АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ХУВААРЬ

| № | Байгууллагын нэр | Хариуцах албан тушаалтны овог нэр | Эрхэлж буй ажил | Утасны дугаар | Постонд гарах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн Онцгой байдлын газар | А/х С. Энх-эрдэнэ | Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн | 91047188 | 05.20-06.10 |
| 2 | Аймгийн Цагдаагийн хэлтэс | Цагдаагийн хошууч Б.Шинэбаяр | Сумын Цагдаагийн хэсгийн дарга | 99595934 | 05.20-06.10 |
| 3 | Сумын мэргэжлийн анги туслах ажилтан | Засаг даргын Тамгын газар Д.Отгонжаргал | Тамгын газрын дарга | 88116503 | 05.20-06.10 |

173